

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТУХАЙ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 6 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Г.Баярсайхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын нэр бүхий 11 гишүүнээс Улсын Их Хуралд 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2013 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, дараах санал, дүгнэлтийг гаргаж байна.

Хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл, Ц.Дашдорж, Л.Болд нараас түймрийн аюултай үед иргэн, хуулийн этгээдээс хориглох үйлдлийг тусгасан хэдий ч хүлээлгэх хариуцлага орхигдуулсан, захиргааны ямар хэлбэрийн хариуцлага оногдуулахыг тодорхой болгох, түүнчлэн ойн тооллого, ой зохион байгуулалттай холбоотой нэр томъёог жигдлэх саналыг;

УИХ-ын гишүүн А.Бакей, Г.Баярсайхан нар өөрийн хөрөнгөөр ойн түймэр, хөнөөлт шавьжтай тэмцсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад олгох урамшууллын асуудлыг бие даасан шинэ хэсэг болгон өөрчлөн найруулж, уг журмыг санхүүгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар төсөлд тусгах нь зүйтэй гэсэн саналыг тус тус гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын хэмжээнд нийт 776 байгаль хамгаалагч ажиллаж байгаад бөгөөд үүнээс улсын хэмжээнд аймаг сумдад 551, үүний 66 хувь нь тусгай дунд, бүрэн дунд, бага боловсролтой, курс дамжаа төгссөн байгаль хамгаалагч байгаа бөгөөд тэдэнд “эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох”, “**мод бэлтгэх гэрээ** байгуулах”, “ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийг” олгох эрхийг нарийвчилсан судалгаагүйгээр хуулиар олгох нь зохимжгүй байна. Ойн тухайн хуулиар дээрх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг сумын болон сум дундын ойн анги өгч байгаа учраас хяналт тавих үүрэг бүхий байгаль хамгаалагчид эрх олгох шаардлагагүй тул төслийн 4 дүгээр зүйлийн холбогдох хаалтан доторх “/байхгүй бол сум дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ гэснийг “/байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч” гэж өөрчлөх заалтыг хасах саналыг УИХ-ын гишүүн А.Бакей, Г.Баярсайхан нар гаргалаа.

Дээрх саналтай холбогдуулан хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан түлшний модны эрхийн бичгийг сумын эрх бүхий албан тушаалтан олгодог хүнд суртлыг арилгах үүднээс байгаль хамгаалагчид энэ эрхийг олгох нь зүйтэй гэж үзсэн

бөгөөд энэ төслийн зарчмын гол өөрчлөлт хэмээн тайлбарлав.

Төсөлтэй холбогдуулан гарсан дээрх саналын томъёоллыг хэлэлцэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэнгүй.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ердийн журмаар дагаж мөрдөх нь зүйтэй гэж Байнгын хороо үзсэн болно.

Төсөлтэй холбогдуулан гарсан саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж олонхийн саналаар дэмжигдсэн, дэмжигдээгүйгээр нь бүлэглэн нэгдсэн хуралдаанд танилцуулахаар Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ойн тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа

БАЙГАЛЬ ОРЧИН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН